

АРВАЙХЭЭР СУМ ЗАСАГ ДАРТЫН ТАМГЫН ГАЗРЫН
СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН НАСАНЖАРГАЛ ОВОГТОЙ МӨНГӨНЦЭЦЭГ-ИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин								
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5	6	7		
НЭГ. "ҮНДЭСНИЙ ӨВ СОЁЛОО ХАМГААЛАН, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД											
1	Археологийн олдворуудыг түшиглэн иргэдэд түүх, соёлын өвийг сурталчлах, хамгаалах ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	-	1	UNN.mn, Montsame.mn сайтуудаар "Буга согоотын хадны зураг", "Арвайн хүрээний модон бар хэвлэл"-ийн талаар цахим орчинд мэдээлэл хүргэсэн 30 000 гаруй хандалт авсан. Археологийн олдворуудаас хүрэл зэвсгийн үе, хүннүгийн үе, түрэгийн үе, монголын эзэнт гүрний үед хамаарах дурсгалын талаар "Arkheer Guide" постероор "Бидний хот-Бидний өв Хамтдаа хамгаалъя" уриан дор цахим орчинд 5 удаагийн мэдээлэл хүргэсэн иргэдэд сурталчилж байна. Археологийн судалгааны олдворуудыг багуудын нутаг дэвсгэрийн тархацаар нь хуваарилан 3,4,6,7,8,10,11 дүгээр багийн ажлын албуудад дурсгалын тодорхойлолт, байршлын мэдээллийг хүргүүлсэн.					2025.01.10 2025.11.28	100
2	Морин хуурыг түгээн дэлгэрүүлэх сурталчлах ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга схэмжээний тоогоор	1	4	МУ-ын Ерөнхийлөгчийн "Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх тухай" зарлигийг сурталчлах, түгээхэд байгууллагын албан хаагчид өөрсдөө үлгэрлэн эхлэх зорилгоор "Морин хуураа дээдэлсэн хамт олон" аян өрнүүлж, орон нутгийн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин 5.6 сая төгрөгийн 20 морин хуур захиалж бүх албан хаагчид гэртээ морин хуур дээдлэн залсан. Ахмад морин хуурчийн морин хуурийн сургалт явуулах					2025.01.10 2025.06.10	93

					санаачилгыг дэмжин ЕБ-ын 4 дүгээр сургуулийн дугуйлангийн хуваарт оруулан нийт 15 хүүхдийг хамруулахаар сургалтыг эхлүүлсэн. Ингэснээр сумын хэмжээнд 2024 онд морин хуурын 2 дугуйланд 35 хүүхэд суралцаж байсан бол энэ онд 3 дугуйланд 49 хамрагдаж сургалтын тоо 1-ээр, суралцагч хүүхдийн тоо 14-өөр нэмэгдсэн байна. "Суралцагч хот - Арвайхээр" нээлттэй хаалганы өдөрлөгт иргэдийн оролцоотой өв соёлыг сурталчлан "Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлбэ" Ерөнхийлөгчийн зарлигт өрх бүр гэртээ морин хуур залах тухай талаар 99 иргэнд мэдээлэл сурталчилгаа өгч, 15 өрхийн морин хуурыг ёсчлон хөглөж өгсөн. Өндөр гэгээн Занабазарын мэлмий гийсний 390 жилийн ойт тохиолдуулан аймгийн Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын газар, аймгийн Хөгжимт драмын театрын өсвөрийн морин хуурын чуулгантай хамтран "Өндөр эгшиглэх хуураа хөглөө" аянг зохион байгуулж Ерөнхий боловсролын 5 сургуульд зочлон багш сурагчдад морин хуурын тоглолт, морин хуурын тухай мэдлэг олгож, морин хуур хөглөх арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.		
3	Өв соёл, уламжлалыг сурталчлах арга хэмжээ зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	-	1	Морьт харвааг орон нутагт хөгжүүлэх эхлэлийг тавьж "Арвайн дайчид клуб"-ыг үүсгэн байгуулж, сургалтын хэрэгсэлд 16,3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн заал танхимаар хангаснаар 11 хүүхэд тогтмол хамрагдсан. "Арваатар хээр адууын баар"-ын үеэр зохион байгуулсан "Морьт харвааны клубүүдийн аварга шалгаруулах тэмцээн"-д Казахстан, Хятад, Турк, Франц улс, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн 12 клубын 40 гаруй тамирчид оролцсон. Мөн "Арвайн дайчид клуб"-ын тамирчид "Улсын аварга шалгаруулах тэмцээн"-д анх удаа оролцож хүүхдийн төрөлд мөнгөн медаль хүртэж, клубын дасгалжуулагч багш БНХАУ-ын ӨМӨЗО-ны Улаанбуланд зохион байгуулагдсан "Дээдсийн ан" буюу Royal hunting Морьт харвааны насанд хүрэгчдийн	2025.09.10 2025.11.10	100

					тэмцээнд "Кбак" төрөлд аваргын "алтан" медаль хүртсэн зэрэг амжилттай байна. Нумт харвааг хөгжүүлэх ахмадын санаачилгыг дэмжин 2, 7 дугаар багийн төвийн зааланд 2 дахь жилдээ үнэ төлбөргүй хичээллүүлж 54 ахмад тогтмол хамрагдаж байгаа бөгөөд үүнээс улс, аймгийн цолтой 16 харваач, эмэгтэй 20, эрэгтэй 34 ахмад харваачид хамрагдаж байна. Тус ахмадуудаас санаачлан а "Нумт харвааны аварга шалгаруулах" анхдугаар тэмцээнийг зохион байгуулахад 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 12 багийн 70 гаруй ахмад оролцсон.		
4.	Соёлын биет бус өвийн бүртгэл судалгааг хөтөлж, хүүхэд залуучуудад өвлүүлэх сурталчлах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ тоогоор	-	1	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч төв халхын үндэсний хувцас урлал, морин хуур, эсгий урлал, сийлбэр, монгол ардын ботигийн дуу гэсэн 7 ай савын 12 өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулсан. Морин хуурч, урлаач Ц.Адъяахүүтэй хамтран шавь сургалт эхлүүлэн ЕБ-ын 4 дүгээр сургуулийн дугуйлангийн хуваарьт оруулан сургалтыг эхлүүлсэн.	2025.01.10 2025.06.10	100
5.	Угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх сургалт, арга хэмжээ зохион байгуулж, угийн бичиг хөтөлдөг иргэдийн тоог нэмэгдүүлнэ	Угийн бичиг хөтөлдөг иргэдийн эзлэх хувиар	31.1	50	Багийн угийн бичиг хөтлөлтийн сургалч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж 13 багт сургалч багш бэлтгэн, сар бүрийн 15-ны 11:00 цагт мэдээлэл, зөвлөгөө солилцож хэвшсэн. Мөн багийн ахмадын зөвлөллүүдэд сумын ахмадын холбооны нийгмийн ажиглан Д.Энхтуяатай хамтран угийн бичгийн хөтлөлтийг иргэд, ахмадуудад сурталчлах, уриалах арга зүйн талаар сургалт зохион байгуулж багийн 23 ахмад хамруулсан. Мөн 05 дугаар сарын 12-нд Насан туршийн суралцахуйн төв, ахмадын холбоотой хамтран 13 багийн Засаг дарга, нийгмийн ажиглан, ахмадын зөвлөлийн дарга нарт "Өрх бүрд угийн бичиг" сургалтыг зохион байгуулж угийн бичгийн эрхзүйн орчин, угийн бичиг хөтлөх аргачлалын талаар сургалт өгсөн. "Удмаа хайрлаа – Хуураа дээдэлбэ" угийн бичиг, морин хуурын өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх сургалт арга хэмжээнд 13 багийн 39 өрхийн 78 иргэнд ахмад, дунд, залуу үеэс төлөөлүүлэн сонгон оролцуулсан. Тус арга хэмжээгээр Сумын ахмадын холбоо, Насан	2025.02.20 2025.06.10	100

	Номын сангийн цахим үйлчилгээг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	1	2	Туршийн суралцахуйн нэгжтэй хамтран үгийн бичиг хөтлөх аргагүй, үлгэр жишээ үгийн бичгийн үзэсгэлэн, морин хуурын өв соёлын мэдээллийг хүргэж, Төрийн Тэргүүний зарлигийг хэрэгжүүлэн өрх бүр гэртээ морин хуураа дээдлэн залах, үгийн бичгээ хөтлөн өвлүүлэхийг уриалж сурталчиллаа.		
6.					Байгууллагын албан хаагчдын өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээнд зориулан 4 таблеланд хууль эрхзүй, уран зохиол, нийгмийн ухаан, танин мэдэхүй, улс орнуудын түүх, эдийн засаг, бизнес, хөдөө аж ахуй улс төр 8 төрлийн 200 гаруй цахим ном суулган албан хаагчдад картаар олгож уншуулж байна. Төв номын сангийн зарласан "Соёлын орон зай - Бидний орчин" аяныг Ерөнхий боловсролын сургуулиудад сурталчлан, заавал унших номын жагсаалтыг, электрон каталогт, шинээр орсон цахим номын QR хувилбарын хамт сургуулийн номын сангуудад байршуулан суралцдад түгээсэн.	2025.08.20 2025.12.01	100
ХОЁР. "АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУРТАЛЧЛАХ МЭДЭЭЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Өндөр гэгээн Занабазарын цэцэрлэгт хүрээлэнд аялал жуулчлалын мэдээллийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна.	Мэдээллийн төв	-	-	Өндөр гэгээн Занабазарын мэлмий гийсний 390 жилийн ой, "Арвагар хээр адууны баяр" арга хэмжээнүүдийн бэлтгэл ажил, зохион байгуулалт, "Өндөр гэгээн Занабазарын цэцэрлэгт хүрээлэнгийн дэг" батлагдсантай холбогдуулан цэцэрлэгт хүрээлэнгийн бүтэц орон тоо, тохижилтын зураг төсөвт тусган уялдуулж, тохижилтыг нарийн тооцоолох шаардлагатайгаар энэхүү ажлыг хойшлуулах шаардлагатай болсон.	2025.05.01 2025.10.01	30

					шалгаруулалтын журмыг боловсруулан сумын ИТХ-аар шийдвэрлүүлэх саналыг хургуулэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.		
2	Өв соёл, уламжлалыг харуулсан эвент арга хэмжээ зохион байгуулна	Арга хэмжээ	-	1	Монгол адууны онцлог шинж чанар, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, олон улсад сурталчлах зорилгоор "Арвагар хээр адууны баяр" аялал жуулчлалын эвентийг аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, Өндөр гэгээн Занабазарын дэглэсэн "Гүүний үр, сүү гаргах" ёслолд 10 малчин өрх, "Морьтон парад" арга хэмжээнд 19 сумын 400 гаруй морьтон, морины эдлэл хэрэглэл, гангараагаар дамжуулан төв халхын хийц, монгол дархны үр урлалыг харуулсан "Сайхан морьтой хос" шалгаруулах уралдаанд 19 сумын 38 хос морьтон, морины хурд хүч, уналгаа эдэлгээ, адуучны авьяас самбааг сорьсон "Эзэнт гүрний морин өртөө" буухиа уралдаанд 18 сумын 72 адуучин, "Тэглэн жороо" жороо морины уралдаанд Завхан, Ховд, Архангай, Говь-Алтай, Булган, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн жороо морьтнууд ирж оролсон юм. Мөн тус эвентийн үеэр "Уяан дунд урласан үр ухаан" морины эд хэрэгслийн үзэсгэлэн худалдаанд 30 гаруй иргэд сур, суран эдлэл, бүрэн тоноглог бүхий эмээл хазсаар, гөлөм тохом, ширэн хөхүүр, гэрэл зураг, уран зураг зэрэг бүтээлээр оролцож, морины өв соёлыг урлагтай холбон "A work of art horse" 1000 морины туурайн зураг зурах урлаг, өв соёлын өвөрмөц арга хэмжээ зэрэг адуу болон адуучны өв соёлыг сурталчлах 12 төрлийн арга хэмжээ зохион байгуулагдаж гадаад, дотоодын 6000 гаруй зочид оролцож, худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд 1.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.	2025.07.01 2025.08.31	100
3	Орон нутгийн онцлогт тохирсон эвент арга хэмжээ зохион байгуулах.	Арга хэмжээ	1	-	Домогт адууны нэрээр нэрлэгдсэн хотын хувьд адууны түүх соёлыг түшиглэн "Арвагар хээр адууны баяр" аялал жуулчлалын эвентийг аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, Өндөр гэгээн Занабазарын дэглэсэн "Гүүний үр, сүү гаргах" ёслолд 10 малчин өрх, "Морьтон парад" арга хэмжээнд 19 сумын 400 гаруй	2025.07.01 2025.08.31	70

					морьтон, морины эдлэл хэрэглэл, гангараагаар дамжуулан төв халхын хийц, монгол дархны ур урлалыг харуулсан "Сайхан морьтой хос" шалгаруулах уралдаанд 19 сумын 38 хос морьтон, морины хурд хүч, уналгаа эдэлгээ, адуучны авьяас самбааг сорьсон "Эзэнт гүрний морин өртөө" буухиа уралдаанд 18 сумын 72 адуучин, "Тэлмэн жороо" жороо морины уралдаанд Завхан, Ховд, Архангай, Говь-Алтай, Булган, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн жороо морьтнууд ирж оролсон юм. Мөн тус эвентийн үеэр "Уяан дунд урласан ур ухаан" морины эд хэрэгслийн үзэсгэлэн худалдаанд 30 гаруй иргэд сур, суран эдлэл, бүрэн тоноглол бүхий эмээл хазаар, гөлөм тохом, ширэн хөхүүр, гэрэл зураг, уран зураг зэрэг бүтээлээр оролцож, морины өв соёлыг урлагтай холбон "A work of art horse" 1000 морины туурайн зураг зурах урлаг, өв соёлын өвөрмөц арга хэмжээ зэрэг адуу болон адуучны өв соёлыг сурталчлах 12 төрлийн арга хэмжээ зохион байгуулагдаж гадаад, дотоодын 6000 гаруй зочид оролцож, худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд 1.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.		
4	Арвайхээр хотын виртуал аялалыг сурталж олон нийтэд хүргэх олон талт арга хэмжээ зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	-	1	Сурагчдын бие даалтын долоо хоногийн хүрээнд Мэргэд сургуулийн 3 дугаар ангийн 2 бүлэг, 4 дүгээр сургуулийн 6 дугаар ангийн 1 бүлгийн нийт 104 хүүхдэд виртуалаар аялуулж, виртуал аяллыг QR-аар түгээж эцэг, эхчүүд, хүүхдүүд хамтдаа Арвайхээрийн түүх, хөшөө дурсгалыг судлан ярилцахыг уриалсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн "Хүний эрх-хүртээмжтэй оролцоо" аяны хүрээнд эрүүл мэндийн явуулын үйлчилгээтэй хамтатган гэрээр айлчлан байнгын асаргаатай ахмад, хүүхэд, залуучуудыг виртуалаар аялуулж, хотын түүх, дурсгалыг үзүүлсэн нь тэдэнд орчинтойгоо танилцах боломж олгосон.	2025.03.01 2025.12.31	70

Зорилт 3. БОЛЗОЛ ХАНГАСАН ИРГЭДИЙГ ШАГНАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1.	Ерөнхийлөгчийн "Монгол улсын цол хүртээх одон медалиар	Шаардлага хангасан иргэдийн тоогоор	218	Шаардлага хангасан	Багийн Засаг даргын ажлын алба болон байгууллагуудаас Төрийн дээд шагналаар шагнуулахаар 217 иргэнийг тодорхойлон	2025.02.01 2025.06.01	100
----	--	-------------------------------------	-----	--------------------	---	--------------------------	-----

	шагнах журам батлах тухай” журмын хэрэгжилтийг хангаж ажиллах		иргэдийн тоогоор	ирүүлснийг журмын дагуу хянаж, аймгийн Засаг даргад уламжлан хүргүүлсэн. Э хийн алдар 1,2 дугаар зэргийн одонгоор шагнуулахаар багуудын Засаг даргын ажлын албанаас 201 иргэний хүсэлт, материал ирүүлснийг журмын дагуу хянаж болзол хангасан 200 иргэнийг уламжлан, холбогдох материалыг архив бичиг хэргийн стандартын дагуу архивлан 7 боть материалыг хүргүүлсэн.			
2.	“Арвайхээр сумын шагналын журам”-ыг хэрэгжилтийг хангаж ажиллах	Орон нутагт болон нийгэмд тустай амжилттай ажиллаж хөдөлмөрлөсөн иргэд, малчид, аж ахуй нэгж, байгууллагыг журмын дагуу шагнаж урамшуулах	Шаардл ага хангаса н иргэн, аж ахуй нэгж байгууллагын тоогоор	Журманд заасан тоогоор, шаардлага хангасан иргэн, аж ахуй нэгж байгууллагын тоогоор	2024 онд орон нутагтаа ажиллаж хөдөлмөрлөхдөө байгууллага, орон нутаг, нийгэмд тустай амжилт гаргасан: Тэргүүний байгууллага - 1 Тэргүүний ажилтан – 11 Сумын аварга малчин – 12 өрх Аварга саалычин – 1 Сумын алдарт уяач – 3 Тэргүүний фермер -1 Тэргүүний тариаланч – 3 тус тус шалгаруулан, шагнал гардуулж, амжилт хөдөлмөрийг нийгэд сурталчилсан.	2025.01.10 2025.03.01	100
3	Байгууллагын албан хаагчдын шагналын судалгааг шинэчилж, олон жил үр бүтээлтэй ажилласан албан хаагчдыг шагналд тодорхойлж уламжлан, шагнуулах	Төрийн дээд болон салбар, орон нутаг, байгууллагын шагналаар албан хаагчдын тоогоор	28	Амжилт, үр бүтээлтэй ажилласан албан хаагчдын тоогоор	Албан хаагчдын шагналын судалгааны нэгтгэлийн авсан шагнал, авсан хугацаагаар ялган судлах боломжтой сан болгон шинэчилж 2025 он хүртэлх авсан бүх шагналын судалгааг гаргаж нэгтгэсэн.	2025.01.25 2025.12.31	100

ДӨРӨВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, иргэдээс төрлөн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, шийдвэрлэх тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын сэргийлэх тухай урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй	Ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь	100	100	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажилласан эсэх	Зөрчилгүй ажилласан байна.	Архив албан хэрэг хөтлөх журмын дагуу 2021-2024 оны нийт 21 боть баримт бичгийг архивлан, хөтлөх хэргийн нэрсийн жагсаалт хөтлөн байгууллагын архивт хүлээлгэн өгсөн. Багийн Засаг даргын ажлын албууд болон байгууллагуудаас сумын Засаг даргын жуухаар шагнуулах хүсэлт ирүүлсэн 79 хүсэлтийг Засаг даргад уламжлан шийдвэрлүүлж, салбарын Тэргүүний шагналд 24 иргэний материалыг харьяалах салбарт, Төрийн дээд шагналд 214 иргэний хүсэлтийг аймгийн Засаг даргад уламжлан хүргүүлсэн.	2025.01.25 2025.12.31	100

	нийцүүлэх гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх				Мөн Эхийн алдар 1,2 дугаар зэргийн одонгоор шагнуулахаар 201 өргөдөл ирүүлснээс болзол хангасан 200 иргэнийг уламжлан шийдвэрлүүлж, одон хүртээсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих зөрчил, гомдолгүй ажилласан.		
2.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж нэгжийн болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах	Гүйцэтгэлийн хувиар	-	100	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаанд боловсруулж гүйцэтгэлийг хагас жилээр тайлагнасан.	2025.01.10 2025.12.01	100
3.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр бүрэн гүйцэтгэж байна.	Өгсөн үүрэг даалгаврын тоогоор	-	Өгсөн үүрэг даалгаврын тоогоор	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр гүйцэтгэж ажилласан.	2025.01.01 2025.12.31	100
4.	Байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцох	Оролцох арга хэмжээний хувиар	-	100	Байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд идэвхтэй оролцож ажиллаж байна. 2025 оны 03 дугаар сард албан хаагчдын арга хэмжээнд эрүүл мэндийн шалтгаанаар оролцоогүй ч зохион байгуулалтын ажлын хэсэгт орж бэлтгэл ажлыг хангаж оролцсон, бусад үйл ажиллагаанд тасралтгүй идэвхтэй оролцсон.	2025.01.25 2025.06.15	100
5.	Байгууллагаас зохион байгуулсан сургалт, судалгаанд хамрагдах	Оролцооны хувиар	-	100	Байгууллага, албан хаагчдаас авсан 6 удаагийн судалгаанд бүрэн хамрагдсан.	2025.01.25 2025.12.15	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биел элтийн хувь
		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6	7	
1	Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтыг судлах.	Судалж баримтжуулсан н хичээлийн сэдвийн тоогоор	-	3	Удирдлагын академийн цахим сургалтад 03 дугаар сард "Хүний эрхийн тухай үндсэн ойлголтууд", Төрийн албан хаагчдын хүний эрхэд суурилсан хандлага, иргэдийн эрх ашиг" , "Жендэрийн мэдрэмжтэй харилцаа холбоо"	2024.01.10 2024.11.10	100	

					сэдвүүд, 06 дугаар сард Монгол бичгийн анхан, дунд шатны сургалтуудыг судалж мэдлэг шалгах сорилыг 90-100 хувьтай гүйцэтгэж 2 сертификат авсан.		
2	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжих	Хууль, журмыг бие даан судалж баяжилт хийж тэмдэглэл хөтөлсөн байна.	-	1. СӨХ тухай хууль 2.ЗАОД онгоор шагнах журам	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмуудыг уншин судалж, албан тушаалын шаардлагатай мэдлэг мэдлээлгээ сайжруулахад тогтмол анхаарч, ажилласан.	2025.01.10 2025.06.10	70
3	Монгол бичгийн дунд шатны сургалтанд хамрагдсан байна.	Сертификат	1	1	Удирдлагын академийн цахим сургалтаас Монгол бичгийн анхан шат, дунд шатны сургалтуудыг судалж мэдлэг шалгах сорилыг гүйцэтгэж сертификат авсан. Албан бичгийн боловсруулалтад мэдлэгээ ашиглан ажиллаж байна.	2025.01.10 2025.06.15	100
4.	Цахим хэрэглээ, программын шинэ ур чадвар эзэмшиж хэрэглээндээ нэвтрүүлсэн байна.	Шинэ технологи, ур чадварыг албан хэрэглээндээ нэвтрүүлсэн байна.	-	1	Төрийн байгууллагуудын удирдлагын нэгдсэн систем ERP систем, апп-ыг тогтмол үйл ажиллагаандаа ашиглаж, хэрэглээний чадвараа сайжруулж байна. Мэдээлэл боловсруулахад ChatGPT, Gemini арр програмуудыг албан хэрэглээнд ашиглаж эхлүүлж байна.	2025.01.10 2025.06.15	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

 / Н.МӨНГӨНӨЦЭЦЭГТ /

(Нэр, гарын үсэг)

2025.11.28
(Огноо)

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
НАСАНЖАРГАЛ ОВОГТОЙ **МӨНГӨНЦЭЦЭГ** 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,
ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: **Арвайхээр сумын ЗДТГ**

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
№	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
НЭГ. “ҮНДЭСНИЙ ӨВ СОЁЛОО ХАМГААЛАН, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1.	Археологийн олдворуудыг түшиглэн иргэдэд түүх, соёлын өвийг сурталчлах, хамгаалах ажлыг зохион байгуулна.	60	5	65	65
2.	Морин хуурыг түгээн дэлгэрүүлэх сурталчлах ажлыг зохион байгуулна.	60	5,8	65,8	65,8.
3.	Өв соёл, уламжлалыг сурталчлах арга хэмжээ зохион байгуулна.	60	10	70	70
4	Соёлын биет бус өвийн бүртгэл судалгааг хөтөлж, хүүхэд залуучуудад өвлүүлэх сурталчлах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	60	10	70	70
5	Угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх сургалт, арга хэмжээ зохион байгуулж, угийн бичиг хөтөлдөг иргэдийн тоог нэмэгдүүлнэ	60	10	70	70
6	Номын сангийн цахим үйлчилгээг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	50	10	60	70.
ХОЁР. “АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУРТАЛЧЛАХ МЭДЭЭЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1.	Өндөр гэгээн Занабазарын цэцэрлэгт хүрээлэнд аялал жуулчлалын мэдээллийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна.	30	5	35	23
2.	Өв соёл, уламжлалыг харуулсан эвент арга хэмжээ зохион байгуулна	60	10	70	70
3.	Орон нутгийн онцлогт тохирсон эвент арга хэмжээ зохион байгуулах.	60	42	70	52
4.	Арвайхээр хотын виртуал аялалыг сурталж олон нийтэд хүргэх олон талт арга хэмжээ зохион байгуулна.	60	42	70	70
ГУРАВ. БОЛЗОЛ ХАНГАСАН ИРГЭДИЙГ ШАГНАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					

1.	Ерөнхийлөгчийн зарлиг "Монгол улсын цол хүртээх одон медалиар шагнах журам батлах тухай" журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	60	10	70	70
2.	"Арвайхээр сумын шагналын журам"-ыг хэрэгжилтийг хангаж ажиллах	60	10	70	70
3.	Байгууллагын албан хаагчдын шагналын судалгааг шинэчилж, олон жил үр бүтээлтэй ажилласан албан хаагчдыг шагналд тодорхойлж уламжлан, шагнуулах	60	10	70	70
ДӨРӨВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, иргэдээс төрөн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэх гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	60	10	70	70
2.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж нэгжийн болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах	60	5	65	65
3.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр бүрэн гүйцэтгэж байна.	60	10	70	70
4.	Байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцох	60	10	70	70
5.	Байгууллагаас зохион байгуулсан сургалт, судалгаанд хамрагдах	60	10	70	70
Дундаж оноо:					65,6

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтыг судлах.	100	15	15
2.	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжих	80 70	12 10,2	10,2
3.	Монгол бичгийн дунд шатны сургалтанд хамрагдсан байна.	100	15	15
4.	Цахим хэрэглээ, программын шинэ ур чадвар эзэмшиж хэрэглээндээ нэвтрүүлсэн байна.	100 90	13,5	13,5
Дундаж оноо				13,4

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ	Үнэлгээний багийн хянан
-----	----------	------------------------	-------------------------

		(0-7 оноо)	баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	7	7
4.	Хариуцлагатай байдал	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	7	7
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	7	7
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	7	7
Дундаж оноо		7	7

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	7,91
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		7,97

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 65,6
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 13,4
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 7,97
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		93,9

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Засаг даргын Тамгын газрын дарга /С.Ганчимэг/
(албан тушаал) (гарын үсэг) (албан хаагчийн нэр)

..... (огноо)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

САЖХМэргэжилтэн

.....

Н.МӨНГӨНЦЭЦЭГ

(албан тушаал)

(гарын үсэг)

(албан хаагчийн нэр)

2025.11.28 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч

З.ХҮҮТн дарга
(албан тушаал)



(гарын үсэг)

С.Тогтоолор
(албан хаагчийн нэр)

(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга

(албан тушаал)

(гарын үсэг)

/...../
(албан хаагчийн нэр)

(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

(албан тушаал)

(гарын үсэг)

/...../
(албан хаагчийн нэр)

(огноо)